



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/520

Булган сум

**Агентлагийн дарга нарын 2023 оны
эхний хагас жилийн гүйцэтгэлийн
төлөвлөгөөг дүгнэсэн тухай**

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний урамшууллыг батлагдсан төсөвтөө багтаан гаргахыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн байдалд шинжилгээ хийж, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг заалт нэг бүрээр нь хяналтад авч, биелэлтийг бүтэн жилээр тооцож тайлагнахыг агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



6323030534

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 29-ны өдрийн А/520 дугаар
захирамжийн хавсралт

**Агентлагийн дарга нарын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн
төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ**

Д/д	Агентлагийн нэр	Үнэлгээ хувиар	Тайлбар
1	2	3	4
1	Онцгой байдлын газар	70.0	-
2	Цагдаагийн газар	73.9	-
3	Шүүхийн шинжилгээний хэлтэс	66.6	-
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	67.3	-
5	Улсын бүртгэлийн хэлтэс	80.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	90.0	40 хүртэлх хувийн урамшуулал олгох
7	Татварын хэлтэс	94.4	40 хүртэлх хувийн урамшуулал олгох
8	Орон нутгийн өмчийн газар	85.6	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
9	Боловсрол, шинжлэх ухааны газар	92.3	40 хүртэлх хувийн урамшуулал олгох
10	Эрүүл мэндийн газар	83.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
11	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	81.7	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
12	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	85.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
13	Нийгмийн даатгалын хэлтэс	90.0	40 хүртэлх хувийн урамшуулал олгох
14	Биеийн тамир, спортын газар	81.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
15	Хүнс, хөдөө аж ахуйн газар	80.6	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
16	Байгаль орчин аялал жуулчлалын газар	71.4	
17	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	83.5	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
18	Мал эмнэлгийн газар	70.2	-
19	Статистикийн хэлтэс	81.6	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
20	Стандарт хэмжил зүйн хэлтэс	82.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
21	Ус цаг уур орчны шинжилгээний төв	88.4	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
22	Соёл урлагийн газар	89.6	30 хүртэлх хувийн урамшуулал олгох
23	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	85.0	30 хүртэлх хувийн урамшуулал олгох